ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/21 Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/62 дугаар захирамжийн суудлын автомашин шилжүүлэх тухай 2 дугаар хавсралтад дараах өөрчлөлтийг оруулж, жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгийг дуудлагаар худалдах, шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвшөөрсүгэй.

3. Хавсралтаар баталсан хөрөнгийг байгууллагынхаа данс бүртгэлээс хасах, дуудлагын худалдааны орлогыг журмын дагуу аймгийн хөрөнгө борлуулсны орлогын данс болон холбогдох дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

а. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

б. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

в. Худалдсан, актлалсан тээврийн хэрэгслийг “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын нэгдсэн бүртгэлээс хасуулсан, шилжүүлсэн тухай тайланг ирүүлэх.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Г.МӨНГӨНХУЯГ

6710001212

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны
өдрийн 42 дугаар захирамжийн хавсралт

а/ Тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ /төг/	Байгуулсан элэгдэл /төг/	Үлдэгдэл үнэ /мян.төг/	ОНӨГ-ын үнийн санал /төг /	Аймгийн ИТХ-ын шийдвэр /төг /
1	Рэнчинлхүмбэ	Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв	ХӨА-0020, М.В-nz	2017	ш	1	59,000,000.00	55,004,666.36	3,995,333.64	Худалдах, 3,900,000	
2	Хатгал	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон эрүүл мэндийн төв	ХӨА-4442, УАЗ-220695 фургон	2017	ш	1	29,736,434.00	29,736,434.00	0.00	Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Цагдаагийн тасагт шилжүүлэх	
Дүн							**59,000,000.00**	**55,004,666.36**	**3,995,333.64**		

оОо